

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ДАРХАН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ ААТҮГ-ЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: ДАА-2022/11/НА-СА-ОНА

Цахим хуудас:  
reakomaudit@gmail.com  
Дархан-Уул аймаг  
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**  
Утас: **7037-3089**  
Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)  
Ахлах аудитор: **С.Батцэцэг**  
Утас: **7037-3089**  
Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)  
Аудитор: **Б.Жаргалсайхан**  
Утас: **9986-2066**  
Цахим хаяг: [batjargalsaikhan@gmail.com](mailto:batjargalsaikhan@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.9. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	13

### Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДАРХАН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ  
ААТҮГ-ЫН ДАРГА  
Б.БАТБАЯР ТАНАА

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дархан дахин төлөвлөлт ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл

Дархан-Уул аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр тогтоолоор Дархан дахин төлөвлөлт ААТҮГ-ыг байгуулсан бөгөөд 2020 оны 3 дугаар сараас үйл ажиллагаа нь эхэлсэн байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан бөгөөд аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд Засаг даргын тамгын газраас дамжуулан 76,765.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 3,686.3 мянга, нийт 81,252.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 79,172.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган 2,080.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

#### Бусад асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан ба цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй болно.

#### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 84.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР/

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,208,799.00	3,477,941.95
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	19,000.00	3,242,941.95
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,000.00	3,242,941.95
31210	Төгрөг	19,000.00	3,242,941.95
31213	Арилжааны банк дахь харилцах	19,000.00	3,242,941.95
33	<b>АВЛАГА</b>	954,799.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	350,000.00	0.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	604,799.00	0.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	235,000.00	235,000.00
35400	Хангамжийн материал	235,000.00	235,000.00
35470	Бусад хангамжийн материал	235,000.00	235,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,524,591.71	1,535,491.80
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,524,591.71	1,535,491.80
39200	<b>Биет хөрөнгө</b>	1,524,591.71	1,535,491.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	800,000.00	1,000,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,333.32	-158,333.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	841,000.00	841,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-63,074.97	-147,174.93
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	2,733,390.71	5,013,433.75
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	200,000.00
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	200,000.00
41300	Өглөг	0.00	200,000.00
41360	Бусад өглөг	0.00	200,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	200,000.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	2,733,390.71	4,813,433.75
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,733,390.71	4,813,433.75
51200	Хуримтлагдсан үр дүн	2,733,390.71	4,813,433.75
51220	Тайлант үеийн үр дүн	2,733,390.71	2,080,043.04
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	2,733,390.71	5,013,433.75

Пийк-Ом Аудит ХХК

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	65,647,000.00	81,252,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,696,900.00	4,486,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,696,900.00	4,486,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,696,900.00	3,686,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,696,900.00	3,686,300.00
120009	Бусад орлого	0.00	800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,950,100.00	76,765,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,950,100.00	76,765,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,950,100.00	76,765,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	62,913,609.29	79,172,056.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,913,609.29	79,172,056.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,863,609.29	79,052,056.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,133,188.00	61,562,876.00
210101	Үндсэн цалин	46,133,188.00	61,562,876.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,553,202.00	8,363,301.05
210201	Тэтгэврийн даатгал	921,604.00	6,023,364.05
210202	Тэтгэмжийн даатгал	454,247.00	625,634.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	363,396.00	500,508.00
210204	Ажилгүйдлийн даатгал	67,990.00	104,435.00
210205	Эрүүл мэндийн даатгал	745,965.00	1,109,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,439,740.00	1,985,160.00
210401	Бичиг хэрэг	402,000.00	332,400.00
210402	Тээвэр, шатахуун	980,000.00	804,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	560,240.00	472,360.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	159,000.00	152,500.00

Дархан дахин төлөвлөлт ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	338,500.00	223,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>163,000.00</b>	<b>500,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	135,000.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>388,000.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	300,000.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	88,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>97,660.00</b>	<b>5,269,620.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	4,979,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	78,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	19,660.00	90,620.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,088,819.29</b>	<b>1,371,099.91</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,972,411.00	382,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	116,408.29	989,099.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,000.00</b>	<b>120,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,000.00</b>	<b>120,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.00	120,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,733,390.71</b>	<b>2,080,043.04</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>2,733,390.71</b>	<b>2,080,043.04</b>

*Пийк-Ом Аудит ХХК*

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,733,390.71	2,733,390.71
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,733,390.71	2,733,390.71
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,733,390.71	2,733,390.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,733,390.71	2,733,390.71
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,080,043.04	2,080,043.04
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	4,813,433.75	4,813,433.75

Пийк-Ом Аудит ХХК

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>65,647,000.00</b>	<b>81,252,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,696,900.00</b>	<b>4,486,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>7,696,900.00</b>	<b>4,486,300.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>7,696,900.00</b>	<b>3,686,300.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,696,900.00	3,686,300.00
120009	Бусад орлого	0.00	800,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>57,950,100.00</b>	<b>76,765,800.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>57,950,100.00</b>	<b>76,765,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,950,100.00	76,765,800.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>63,987,000.00</b>	<b>77,028,158.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>63,987,000.00</b>	<b>77,028,158.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>63,937,000.00</b>	<b>76,908,158.05</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>41,948,756.00</b>	<b>54,180,684.00</b>
210101	Үндсэн цалин	41,948,756.00	54,180,684.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>7,692,433.00</b>	<b>14,790,694.05</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,692,433.00	14,790,694.05
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,674,740.00</b>	<b>1,985,160.00</b>
210401	Бичиг хэрэг	402,000.00	332,400.00
210402	Тээвэр, шатахуун	980,000.00	804,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	560,240.00	472,360.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	159,000.00	152,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	573,500.00	223,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>163,000.00</b>	<b>500,000.00</b>
210602	Тавилга	28,000.00	500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	135,000.00	0.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>388,000.00</b>	<b>0.00</b>

Дархан дахин төлөвлөлт ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	300,000.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	88,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>97,660.00</b>	<b>5,069,620.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	4,979,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	78,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	19,660.00	90,620.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,972,411.00</b>	<b>382,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,972,411.00	382,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,000.00</b>	<b>120,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,000.00</b>	<b>120,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.00	120,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,660,000.00</b>	<b>4,223,941.95</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,641,000.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,641,000.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,641,000.00</b>	<b>1,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,641,000.00	1,000,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-1,641,000.00</b>	<b>-1,000,000.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>19,000.00</b>	<b>3,223,941.95</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	19,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,000.00	3,242,941.95

*Пийк-Ом Аудит ХХК*

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан дахин төлөвлөлт ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын орлого, зарлагыг холбогдох материалын дансаар бүрэн дамжуулж бүртгэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Б.Жаргалсайхан, аудитор Я.Батбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг “Пийк-Ом Аудит” ХХК-ны чанарын хяналтын менежер Б.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан дахин төлөвлөлт ААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Пийк Ом Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 03 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага нь “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” гэсэн статустай бөгөөд 100 хувь орон нутгийн өмчид харьяалагдаж байна.

Дархан дахин төлөвлөлт ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулан, төлөвлөн барилгажуулах
- Үндсэн тосгон болон туслах тосгоныг дахин төлөвлөн барилгажуулах
- Түрээсийн орон сууцны харилцааг зохицуулах
- Орон сууц үндэсний хөтөлбөрийг орон нутагт зохион байгуулах
- Агаар, орчны бохирдлын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дархан дахин төлөвлөлт ААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж эхлээгүй байна.

#### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант 2021 оны жилийн эцсийн тайлангийн суурь үзүүлэлт нийт зардлын 62,913.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцож 1,258.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дархан дахин төлөвлөлт ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,280.0 мянган төгрөгөөр буюу 83.41 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19.0	3,242.9	3,223.9
Авлага	604.8	0	(604.8)
Урьдчилгаа	350.0	0	(350.0)
Бараа материал	235.0	235.0	0
Үндсэн хөрөнгө	1,524.6	1,535.5	10.9
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,733.4</b>	<b>5,013.4</b>	<b>2,280.0</b>
Өр төлбөр	-	200.0	200.0
Эздийн өмч	2,733.4	4,813.4	2,080.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,733.4</b>	<b>5,013.4</b>	<b>2,280.0</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, өглөг, өмчийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоос 3,242.9 мянган төгрөг арилжааны банкинд үлдсэн байна.

Аудитын төлбөр шилжүүлээгүйгээс 200.0 мянган төгрөгийн байгууллагад өгөх үлдэгдэл үүссэн.

### 3.6. Төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Дархан дахин төлөвлөлт ААТҮГ нь Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 11 сарын 23 ны өдрийн 107 тоот тогтоолоор анх байгуулагдан, 2020 оны 2 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Гүйцэтгэлээр Засаг даргын тамгын газраас дамжуулан 76,765.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 3,686.3 мянга, нийт 81,252.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 79,172.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган 2,080.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд одоогоор бүртгэгдээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах талаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр баримт бичгийг боловсруулан баталсан боловч мөрдөж ажиллах тал дээр учир дутагдалтай байгаа болно.

### 3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 210.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

##### 4.1. Залруулсан алдаа

Тайлант онд залруулахаар алдаа илрээгүй.

##### 4.2. Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

##### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

##### 4.4 Зөвлөмж

###### 1. Хувь хүнд төлөх төлбөрт татвар ногдуулахтай холбоотой

###### 1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 90.0 мянган төгрөгийн ажил бусдаар гүйцэтгүүлэн ажлын хөлс олгохдоо татвар ногдуулаагүй.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогоын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1, 14 дүгээр зүйл 14.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул холбогдох хуулийг мөрдөж ажиллах.

###### 2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

###### 2.1. Илрүүлэлт:

Тайлант онд 120.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

###### 2.2. Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/мян төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан дахин төлөвлөлт ААТҮГ	2	210.0	-	-	-	-	-	-	2	210.0
	Дүн	2	210.0	-	-	-	-	-	-	2	210.0

ПИЙК-ОМ АУДИТ ХХК

2022.02.25